НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

# БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

2023 оны 12 дугаар сарын 11 Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1:** Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4, НХТ 2.4, (3.4) | | | | | | | |
| **1.** | **Зорилт 1: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.1, НХТ 2.4, (3.4)** | | | | | | |
| 1.1 | **Арга хэмжээ-1:** Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ. | Нийслэлийн төсөв 114,665,800 | Төвийн тоо | 5 | 5 | Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг 7 байршилд ажиллуулж үүнээс Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Төв шуудан”, ХБНГУ-ын Фрайбург хот, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд байрлах жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг тогтмол, “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” төвүүд улирлын чанартай ажиллалаа. | 100% |
| 1.2 | **Арга хэмжээ-2:** Жуулчдыг 24 цагийн турш хэрэгцээт мэдээллээр хангах лавлах утасны үйлчилгээг ажиллуулна. | Улсын төсөв 800,000 | Мэдээлэл өгсөн хүний тоо | 5,000 | 7,000 | Жуулчдын санал, хүсэлтийг хүлээн авах, зөвлөгөө, мэдээ мэдээллээр хангах лавлах 118 тусгай дугаарын утсаар 7500 гаруй, жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн 70108687 утсаар 828 нийт 8328 дуудлага хүлээн авч шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав. | 100% |
| 1.3 | **Арга хэмжээ-3:** Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай арга хэмжээнүүдийг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв 364,401,689 | Арга хэмжээ , оролцогч, сонирхогчдын тоо | 8 арга хэмжээ, 52,100 хүн | 8 арга хэмжээ, 60,000 хүн | “Монголд зочлох жил”-ийн хүрээнд хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор 2023 онд 10 арга хэмжээг зохион байгуулж 131,500 гадаад, дотоодын иргэд, жуулчид үзэж сонирхсон.Үүнд: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ “Бүргэдийн баяр”<br>✓ “Playtime” “PRE-EVENT” арга хэмжээ<br>✓ “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль<br>✓ “POWER EXPO & FESTIVAL”<br>✓ “UB bike tour” дугуйн аялал<br>✓ “Талын салхи” олон улсын мото наадам<br>✓ “Playtime” олон улсын амьд хөгжмийн наадам<br>✓ “UB food festival”<br>✓ “Ulaanbaatar walking festival ”<br>✓ “Хийморь” олон улсын морьт харваа болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгууллаа. | |
| 1.4 | **Арга хэмжээ-4:**<br>“Улаанбаатар өвлийн наадам” арга хэмжээг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв 86,113,280 | Оролцогч, сонирхогчдын тоо | - | 10,000 | Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн уламжлалт болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатар өвлийн наадам 2023” арга хэмжээг 2023 оны 02 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд “Скай ресорт” цогцолборт зохион байгууллаа.<br>“Улаанбаатар өвлийн наадам 2023” арга хэмжээний үеэр “Мөсөн сурын Монгол туургатны аварга шалгаруулах тэмцээн”, “Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн”, “Параглайдингийн хотын аварга шалгаруулах тэмцээн”, “Рагбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн”, “Снөүбоардын параллел слалом тэмцээн” зэрэг 5 төрлийн тэмцээн зохион байгуулж ОХУ-ын Буриад, Тува, Халимаг улсаас 30, БНХАУ-ын ӨМӨЗО-оос 6, Монгол Улсын 21 аймгаас 450, Улаанбаатар хотоос 370 нийт 856 хүн оролцов. Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хананд авирах, мөсөн сур, мөсний шагай, “АХА”, гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээн болон урлагийн тоглолт, open mic, параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, цана чарга, нохой чарга, хоол ундны үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг нийт 10,000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид үзэж сонирхсон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | **Арга хэмжээ-5:**<br>“Дээлтэй Монгол” наадам арга хэмжээг зохион байгуулна. | Улсын төсөв 30,000,000<br><br>ҮИБНЗБХЗ 35,000,000 | Оролцогч, сонирхогчдын тоо | 10,000 | 10,000 | Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Соёлын яам, Хүүхэд, залуучуудын театр, Монголын Аялал жуулчлалын холбоо, “Монгол костюмс” ХХК-тай хамтран Үндэсний хувцасны өдөр “Дээлтэй Монгол наадам-2023” арга хэмжээг 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 17 дахь жилдээ зохион байгууллаа.<br>“Дээлтэй Монгол наадам-2023”-ын баярын жагсаалд Монгол туургатан БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймаг, Хөх нуурын Дээд Монголчууд, ОХУ-ын Буриад, Тува зэрэг улсаас 269 хүн, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон 30 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 8348 нийт 8617 хүн оролцсон.<br>Арга хэмжээнд оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг бүжгийн оролцогч, шилдэг дээл урлаач, хамгийн сайхан дээлтэй гэр бүл, хамгийн сайхан дээлтэй эрэгтэй, эмэгтэй оролцогч, үндэсний хувцастай гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 10 номинациар шилдгүүдийг тодруулав. Мөн арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, дээлтэй диско, морьтон баатруудын парад зэрэг арга хэмжээ, 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 168 иргэн, аж ахуй нэгж, байгууллага 40 асарт үндэсний дээл хувцас, эд хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулж арга хэмжээ нийт 15,000 гаруй хүн үзэж сонирхов. | 100% |
| 1.6 | **Арга хэмжээ-6:**<br>“Хүрээ цам-Даншиг наадам” арга хэмжээг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв 176,520,000 | Оролцогч, сонирхогчдын тоо | 30,000 | 30,000 | Монголчуудын уламжлалт өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор Монголчуудын өв соёлын “Даншиг наадам-Хүрээ цам 2023” арга хэмжээг “City of nomads” уриа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дор Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран 2023 оны 08 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд Хүй 7 худагт зохион байгууллаа. “Даншиг наадам-Хүрээ цам 2023” арга хэмжээний үеэр Үндэсний 256 бөх, Буриад 64 бөх, Өвөр-Монгол 64 бөхийн барилдаан болон их нас, хязаалан, жороо морьдын уралдаан, морьт харвааны тэмцээн, сээр цохих тэмцээн, уухай шагайн харвааны тойром, үндэсний сур харвааны тэмцээн, “Хүрээ цам-Майдар” түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн, Монгол үндэсний таван тансаг идээ цайны үзэсгэлэн, Монгол хувцасны үзүүлбэр, Монгол туургатан улсуудын урлаг соёлын “Сити оф номадс” шоу тоглолтоос гадна “Нүүдэлчдийн Нийслэл” эрдэм шинжилгээний хурал болж 9 орны 50 монгол судлаач, түүхч эрдэмтэд Монгол улсын өнө эртний түүх, эрт дээр үеэс уламжлагдан ирсэн өв соёлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа. Арга хэмжээний үеэр Гандантэгчэнлин хийдийн лам хуврагууд хүрээ цам харайх ёслол, “Очирваань” бурхны тахилга, Эзэн Богд Чингис хааны тахилга үйлдэж, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг унзад голч нарын тэмцээн тус тус зохион байгуулагдав.<br>“Даншиг наадам-Хүрээ цам 2023” арга хэмжээнд Буриад, Халимаг Тува, Өвөр-Монгол зэрэг Монгол туургатан улсуудаас 56 хүчит бөх, урлаг, соёлын 20 уран бүтээлч оролцож, Монгол Улсад суугаа 24 элчин сайдын яамны 72 зочид төлөөлөгчид, 3700 орчим жуулчид, дотоодын 50.000 гаруй иргэд үзэж сонирхсон. | |
| 1.7 | **Арга хэмжээ-7:**<br>“Хаадын чуулбар” Чингис хааны мэндэлсэн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | - | Оролцогч, сонирхогчдын тоо | - | 2000 | Эзэн богд Чингис хааны мэндэлсэн өдөр “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан түүх соёлынхоо уламжлалыг дэлхий дахинд сурталчлан таниулах, жуулчдыг татах шинэ бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Чингис хааны Эш хөргийн тахилга “Хаадын чуулбар” | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | арга хэмжээг 2023 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэлийг ханган ажилласан ч төсөв батлагдаагүй болно. | |
| 1.8 | **Арга хэмжээ-8:** “Хүннүгийн язгууртны булш” орчны тохижилтын ажлыг үргэлжлүүлэн аяллын эргэлтэд оруулна. | Нийслэлийн төсөв 351.3 | Тохижилтын ажлын явц, хувиар | 30 | 100 | Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/926 дугаар захирамжаар Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажил он дамжин хийхээр төсөв батлагдаж ажлын график төлөвлөгөөний дагуу 400 мк2 явган хүний зам, авто машины зогсоол, 420 м урт гадна хашаа, ариун цэврийн байгууламж зэрэг ажлууд хийгдэж тохижилтын ажил үерийн усаас үүдэлтэй хөрсний нуралтаас шалтгаалан 80 хувийн гүйцэтгэлтэй байна. | 70% |
| 1.9 | **Арга хэмжээ-9:** “Тэрбум” мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Нэг жуулчин-нэг мод” жуулчны төглийн тохижилтын ажлыг үргэлжлүүлж дуусгана. | - | Тохижилтын ажлын явц, хувиар | 30 | 100 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд гадаад, дотоодын аялагч, жуулчид мод тарих боломжийг бүрдүүлэх, иргэд жуулчид чөлөөт цагаа өнгөрүүлэх боломжийг бүрдүүлэх “Жуулчин төгөл” бий болгох зорилгоор Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажлыг 2022 онд эхлүүлж 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгасан.<br>2023 онд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “Монгол-Солонгос”-ын аялал жуулчлалын тур операторуудын форумд оролцогч “КТАС” БНСУ-ын жижиг, дунд аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд, Монголын солонгос зах зээлийн тур операторын холбоо болон Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн байгууллагууд, “Цолмон трэвал” ХХК, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран мод тарих ажлыг 2 удаа зохион байгуулж улиас, монос, шинэс, нохойн хошуу, тэхийн шээг, хавилгана зэрэг нийт 8 төрлийн 230 гаруй мод тарих ажлыг зохион байгуулж “Жуулчин төгөл”-д нийт 18 төрлийн 510 мод тарих ажлыг зохион байгууллаа. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.10 | **Арга хэмжээ-10:**<br>Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлын хүрээнд тохижуулах газрын асуудлыг шийдвэрлүүлнэ. | - | Газрын тоо | - | 3 | Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах, тэдгээрийн орчныг хадгалан хамгаалах зорилгоор “Гачууртын амны хадны зураг”, Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны цогцолбор”, “Туулийн хар түнийн ордны туурь”, “Ар гүнтийн дөрвөлжин булш”, мөн “Улаанбаатарт үйлдвэрлэв” аутлэт төв байгуулах зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 33 дугаар хороо, Эмээлт орчим, Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Тэрэлж, Гордок салдаг уулзвар орчим зэрэг нийт 6 газрын кадастрын зураг хийж, газрын эрхийг баталгаажуулах хүсэлтийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн.<br>Музей, түүх, соёлын дурсгалт газрын зориулалтаар Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны цогцолбор” орчмын 56777м.кв газар, “Туулийн хар түнийн ордны туурь” орчмын 120073м.кв газар, Аялал жуулчны баазын зориулалтаар Налайх дүүргийн 1 дүгээр хорооны “Улаанбаатарт үйлдвэрлэв” аутлэт төв байгуулах 3000м.кв газрын асуудлыг шийдвэрлүүлж эзэмших эрхийн гэрчилгээ авсан. | 100% |
| **2.** | **Зорилт 2: Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-3.4.2, НХТ 2.4, (3.4)** | | | | | | |
| 2.1 | **Арга хэмжээ-11:**<br>Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад, дотоодын олон нийтийн сүлжээгээр болон дэлхийд алдартай аялагч нараар дамжуулан сурталчлан таниулна. | Нийслэлийн төсөв 36,315,000 | Контентын тоо | 3 | 3 | “Монголд зочлох жил”-ийн хүрээнд Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор 3 нэвтрүүлэг, 1 клип, 7 контент хийсэн. Үүнд:<br>✓ Оросын Холбооны Улсын Красноярск хязгаарын "Красноярск" телевиз, радиогийн улсын байгууллагатай хамтран Улаанбаатар хотын тухай танилцуулга аяллын нэвтрүүлэг<br>✓ “Keshet broadcasting Ltd”, “Титэм говь” ХХК-тай хамтран Израил Улсын “The Amazing Race Israel” телевизийн аяллын шоу нэвтрүүлэг<br>✓ “Улаанбаатарын үдэш" дууг (хятад хэл) дуулж 250 сая гаруй хүнд хүргэсэн БНХАУ-ын “Чинхай” мужийн “Гүйнань” хотын ээж хүү | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хоёр уран бүтээлчдийн дууны клипний зураг авалт<br>✓ Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны хамтын ажиллагааны хүрээнд “Монгол цайны тухай” нэвтрүүлэг<br>✓ Улаанбаатар хотын аялал жуулчлалын тухай 2 контент “Улаанбаатар өвлийн наадам”, “Бүргэдийн баяр”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Хийморь” морьт харвааны наадам “Улаанбаатар олон улсын хоолны фестиваль” зэрэг эвент арга хэмжээнүүдийн талаарх богино хэмжээний 5 контент нийт 7 контент хийж үйл ажиллагаа сурталчилсан. | |
| 2.2 | **Арга хэмжээ-12:**<br>Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном зэрэг тараах материал шинэчлэн гаргана. | Нийслэлийн төсөв 81,250,000 | Материалын тоо | 10,000 | 10,000 | Улаанбаатар хотын сурталчилгааны сэтгүүл 9000 ширхэг, (Англи, Солонгос, Япон, Герман, Орос, Хятад хэлээр), Улаанбаатар хотын хөтөч ном 1500 ширхэг (Англи хэлээр), Улаанбаатар хотын газрын зураг 5000 ширхэг нийт 15,500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажилласан. | 100% |
| 2.3 | **Арга хэмжээ-13:**<br>Дотоодын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран аялал жуулчлалын боловсрол олгох нэвтрүүлэг, булантай болно. | - | Нэвтрүүлэг, булан бий болгосон тоо | - | 2 | “Дэлхийн Монголчуудын MGL” радиогийн “Дөрвөн зүгийн шуугиан”, “Өдөр тутмын мэдээ”, “Пин пост” 3 нэвтрүүлгээр аялал жуулчлалын боловсролын талаар болон жуулчдад зориулан зохион байгуулсан 9 эвент арга хэмжээнүүдийн тухай давхардсан тоогоор нийт 30 гаруй мэдээ, мэдээллийг цувралаар олон нийтэд хүргэсэн. | 100% |
| 2.4 | **Арга хэмжээ-14:**<br>Түүх соёлын дурсгалт газруудад Кью Ар /QR/ код уншуулж, цахим хөтчөөр дамжуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлнэ. | Нийслэлийн төсөв 10,000,380 | /QR/ код байршуулах дурсгалт газруудын тоо | - | 5 | Улаанбаатар хотын түүх соёлын дурсгалт газрууд, хөшөө баримлууд буюу жанжин Д.Сүхбаатарын морьт хөшөөний цогцолбор, Тусгаар тогтнолын хөшөө, Дашдоржийн Нацагдоржийн хөшөөний дурсгал, Зайсан толгой-зөвлөлтийн дайчдын хөшөөт цогцолбор, Монголын Үндэсний музей, Монгол Улсын Төрийн дууллын үг бүхий дурсгал, “Халуун элгэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нутаг” дууны хөшөө, “Богд хааны хөшөө”, “Тэмээн жингийн цуваа” зэрэг 21 байршилд Кью Ар /QR/ код бүхий мэдээллийн самбар байршуулж гадаад, дотоодын иргэд, жуулчид 5 хэл дээр (Монгол, Англи, Хятад, Япон, Солонгос) цахим хөтчөөр дамжуулан мэдээлэл авах боломжийг бүрдүүлж мөн https://ub-places.site/ цахим хуудсанд 21 газрын дэлгэрэнгүй мэдээллийг, хаяг байршлын хамт байршуулж олон нийтэд сурталчлан ажилласан. | |
| 2.5 | **Арга хэмжээ-15:**<br>"Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо"-той хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | Нийслэлийн төсөв 6,620,000 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | Улаанбаатар хот Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд (World Tourism Cities Federation) 2022 онд элссэн. Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбооноос БНХАУ-ын Хунань мужийн Чанша хотод 2023 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд зохион байгуулсан “Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт”-д Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Д.Батсүх нар оролцлоо. “Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт”-д БНХАУ-д суугаа 8 Улсын Элчин сайд, 37 улсын WTCF-ийн хот, байгууллагуудын гишүүд болон дэлхийн аялал жуулчлалын томоохон аж ахуйн нэгжүүдийн 400 гаруй төлөөлөгчид оролцож арга хэмжээний үеэр Улаанбаатар хот Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд элссэн батламжаа авлаа.<br>Уулзалтаар “Аялал жуулчлалын сэргэлт”, “Сорилт ба хамтын ажиллагаа”, “Хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх шинэ аргачлал” сэдэвт илтгэлүүд явагдаж, 2023 оны аялал жуулчлалын эдийн засгийн чиг хандлага, Дэлхийн хотуудын Ковид цар тахлын нөхцөл дэх тогтвортой хөгжлийн тайланг хэлэлцэж, хөрөнгө оруулалтыг дэмжих хурал, B2B уулзалт зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | **Арга хэмжээ-16:**<br>Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор олон улсын арга хэмжээнд оролцох, зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Нийслэлийн төсөв 155,373,286 | Арга хэмжээний тоо | 7 | 7 | Монгол Улсын Засгийн газраас 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлсэнтэй холбогдуулан Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор 2023 онд Гадаад харилцааны яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоо, олон улсын байгууллагууд, тур оператор компаниудтай хамтран олон улсын 8 үзэсгэлэн арга хэмжээнд оролцож, 5 үзэсгэлэн арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:<br>Оролцсон арга хэмжээнүүд:<br>✓ “Messe Stuttgart CMT-2023“ олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн<br>✓ “ITB Berlin-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн<br>✓ “Монгол-Хятад 2 улсын аялал жуулчлалын зөвлөлийн уулзалт”<br>✓ “SITIF” сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн<br>✓ “Чанша анхилам уулс аялал жуулчлалын дээд хэмжээний чуулга уулзалт”<br>✓ “Олон улсын эдийн засаг худалдаа хөрөнгө оруулалтын эрээн хот чуулга уулзалт”<br>✓ “Цайны зам” олон улсын соёл, аялал жуулчлалын хурал<br>✓ “JATA-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн<br>Зохион байгуулсан арга хэмжээнүүд:<br>✓ “Монгол-Оросын тур оператор компаниудын форум”<br>✓ “Монгол-Солонгосын тур оператор компаниудын форум”<br>✓ Цайны замын олон улсын аялал жуулчлалын холбооны гишүүн аймаг, хот, мужуудын уулзалт<br>✓ "Улаанбаатар травел экспо-2023" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн<br>✓ “ITM Mongolia-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.7 | **Арга хэмжээ-17:**<br>Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн өдрүүдийг Улаанбаатар хотод зохион байгуулна. | Нийслэлийн төсөв 106,240,000 | Арга хэмжээний тоо | 4 | 4 | Найрамдалт харилцаат улс, хотуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх зорилгоор 4 улс, хотуудын аялал жуулчлал, соёлын өдрүүд арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:<br>1.Монгол-Францын соёлын төвтэй хамтран "Франц хэлтнүүдийн хотхон” соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг 2023 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж 5000 гаруй хүн үзэж сонирхсон.<br>2. “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2023 оны 08 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулж арга хэмжээнд БНСУ-аас урлаг соёлын 100 гаруй уран бүтээлчид, 20 гаруй тамирчид оролцож БНСУ-ын Урлагийн их сургуулийн дэвүүрт бүжиг, Хойд Жолла мужийн “Нанта” үзүүлбэр, Солонгосын уламжлалт хөгжмийн үзүүлбэр, “Бибимбаб” хоолны үзүүлбэр, “Жонбук Ариранг” тоглолт, Монгол, Солонгос оркестрын тоглолт, “Күггивон Таэквондо” үзүүлбэр, “MEGAMAX” хамтлагийн тоглолтыг зохион байгуулж арга хэмжээг 25,000 гаруй хүн үзсэн.<br>3. “Япон соёл, аялал жуулчлалын өдөрлөг” (Japan festival) арга хэмжээг 2023 оны 09 дүгээр сарын 09,10-ны өдрүүдэд зохион байгуулж Япон улсаас 170 гаруй зочид төлөөлөгчид, 80 гаруй уран бүтээлчид оролцож, өдөрлөгийн үеэр Япон үндэсний хөгжмийн Этосэтора хамтлагийн тоглолт, Япон косплэй хувцасны үзүүлбэр, Япон орныг хэн сайн мэдэх вэ? асуулт хариултын тэмцээн, Япон дуу хэн сайн дуулах вэ” дууны тэмцээн зохион байгуулагдаж арга хэмжээг 5000 гаруй хүн үзэж сонирхсон.<br>4. Соёлын яам, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран "Дэлхий далайг холбох тэргэл сар–Тэргэл сарны баяр" Монгол-Хятадын хүндэтгэлийн тоглолтыг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулж 2 улсын 100 гаруй уран бүтээлчид оролцож тоглолтыг 500 гаруй хүн үзэн сонирхсон. Мөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар дахь Хятадын соёлын төвөөс "Монгол-Хятадын аялал жуулчлалын семинар"-ийг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгуулж БНХАУ-ын зах зээлд үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын 50 гаруй тур оператор компанийн төлөөллүүд оролцлоо. | |
| **3.** | **Зорилт 3: Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. НЗДҮАХ-3.4.3, НХТ 2.4, (3.4)** | | | | | | |
| 3.1 | **Арга хэмжээ-18:** Жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Оюутан цагдаа-2023” арга хэмжээг үргэлжлүүлэн хамтран зохион байгуулна. | - | Оюутан, цагдаагийн тоо | 150 | 200 | Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор “Оюутан цагдаа 2023” арга хэмжээг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хооронд 2 сарын хугацаанд хэрэгжүүлж Улаанбаатар хотын 21 их, дээд сургуулийн 90 оюутан ажиллалаа.<br>Оюутан цагдаа нар ажиллах хугацаандаа 102 тусгай дугаарт гэмт хэргийн 5, зөрчлийн шинжтэй 17 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 7062, гадаадын 7666 жуулчинд үйлчилгээ үзүүлж, 9 төрлийн 11,680 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тарааж, 66 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгөх ажлыг гүйцэтгэсэн байна. Байгалийн дурсгалт болон түүх соёлын дурсгалт газар, үзвэр үйлчилгээний газрын тухай 7 бүлэг 36 мэдээлэл бүхий QR кодыг гадаадын 6981 жуулчдад танилцуулан ажилласан.<br>“Оюутан цагдаа-2023” арга хэмжээний батлагдсан төсөв санхүүгээс шалтгаалан 90 оюутан ажиллуулсан. | 90% |
| 3.2 | **Арга хэмжээ-19:** Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 2 | 2 | Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран 3 арга хэмжээ зохион байгуулав. Үүнд:<br>1.Гадаад, дотоодын иргэд, жуулчид, аялал жуулчлалын байгууллагуудын санал хүсэлтийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу Улаанбаатар хотод жуулчин ихээр зорчдог газруудын нөхцөл байдал, үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулж “Чингис хааны хөшөөт цогцолбор”, “Зайсан толгой- зөвлөлтийн дайчдын цогцолбор”, “Дамбадаржаа хийд” болон Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах “Мэлхий хад”, “Арьяабал бурхан засалч, бясалгалын төв” зэрэг 12 газар очиж ажиллаж, жуулчдыг ая тухтай, аюулгүй аялах нөхцөл боломжоор хангах, гадна, дотно цэвэрлэгээ, өнгө үзэмж, тохижилт үйлчилгээгээ сайжруулах, нүхэн жорлонг буулгах, стандартын дагуу ариутгал хийж булах, боловсон ариун цэврийн байгууламж байгуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, стандартын дагуу үйлчилгээ эрхлэх талаар заавар зөвлөмж өгч, 4 байгууллагад хийж хэрэгжүүлэх ажлын жагсаалт гарган хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллав.<br>2.Жуулчдын аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гэмт халдлагад өртөх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран "Зөвлөмж" гаргаж “Монголын Аялал жуулчлалын холбоо”, “Монголын Зочид буудлуудын холбоо”, “Мэргэжлийн тур операторуудын холбоо”, “Монголын жуулчны баазуудын холбоо” зэрэг 6 мэргэжлийн холбоодоор дамжуулан аялал жуулчлалын тур оператор компани, зочлох үйлчилгээний байгууллагуудад хүргүүлж хамтран ажилласан.<br>3. Хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газартай хамтран “Монголд зочлох жил”, “Хотын стандартууд”, “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж 5 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 355 удирдах ажилтан хамрагдлаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | **Арга хэмжээ-20:**<br>Зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх замаар и-баримт олголтыг нэмэгдүүлнэ. | - | Нийслэл хотын албан татварт төвлөрүүлэх мөнгөн дүн | 10,000.0 | 10,000.0 | Нийслэл хотын албан татварт 2023 оны эхний 10 сарын байдлаар 12,736,167.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. | 100% |
| 3.4 | **Арга хэмжээ-21:**<br>Зочлох үйлчилгээний байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазуудад стандартын үзлэг зохион байгуулна. | - | Байгууллагын тоо | /-/ | 600 | Аялал жуулчлалын байр сууцаар хангах үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад салбарын холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, үндэсний болон хотын стандартуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах зорилгоор стандартын үзлэг, хяналт шалгалтын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн хооронд холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.<br>Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 71 дэн буудал, 41 зочид буудал, 131 амралтын газар, жуулчны бааз нийт 243 байгууллага, аж ахуйн нэгжийг стандартын үзлэг, хяналт шалгалтад хамруулж, илэрсэн зөрчилд үндэслэн 20 аж ахуйн нэгж, байгууллагад зөвлөмж өгч, Улсын байцаагчийн Албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгаврыг 6 аж ахуйн нэгжид өгч биелэлтийг хангуулан ажилласан бөгөөд зөрчилтэй 3 аж ахуйн нэгжийг тус бүр 500.000 (таван зуун мянган )төгрөгөөр торгож арга хэмжээ авсан. | 70% |
| 3.5 | **Арга хэмжээ-22:**<br>Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр болон олон улсын туршлагыг судлах | Нийслэлийн төсөв 20.0 | Сургалтад хамрагдах хүний тоо | 450 | 450 | Аялал жуулчлалын салбарын байгууллагуудын удирдлага, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр 12 төрлийн 17 удаагийн сургалтыг зохион байгуулж танхимаар 647, цахимаар 2122, нийт 2769 хүнийг хамруулсан. Үүнд:<br>✓ “Солонгос хэлний аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалт 12 хүн, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | экспертүүдийн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна. | | | | | ✓ “Чингис хаан Үндэсний музейд тайлбар хийх” эрх олгох сургалтад 100 хөтөч тайлбарлагч,<br>✓ “Хууль, дүрэм, стандарт” сэдэвт сургалтад салбарын 355 удирдлага, албан хаагч<br>✓ “Оюутан цагдаа 2023” арга хэмжээний сургалтад 90 оюутан,<br>✓ Сайн дурын хөтөч тайлбарлагч нарт зориулсан сургалтад 50 хүн,<br>✓ Салбарын бодлого шийдвэр, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, сургалтад 21 аймаг, нийслэл, дүүргийн 40 төрийн албан хаагч<br>Үйлчилгээний ажилтны ур чадварыг сайжруулах зорилгоор “Угтах үйлчилгээ”, “Зөөгч”, “Өрөө үйлчилгээ”, “Хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох”, “Жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилтнуудын харилцаа хандлага”, “Жуулчидтай харилцдаг төрийн албан хаагчдын харилцаа хандлага” сэдэвт 6 төрлийн цахим сургалтын гарын авлага хичээлийг цахимаар 2122 хүн үзсэн. | |
| 4. | **Зорилт 4: “Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ”-г боловсруулж, хэрэгжүүлнэ. НЗДҮАХ-3.4.4, НХТ-2.4.19** | | | | | | |
| 4.1 | **Арга хэмжээ-23:**<br>“Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 7 зорилтын 77 арга хэмжээний биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 80 хувийн хэрэгжилттэй байна. | 70% |
| 5. | **Зорилт 5: “Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. НЗДҮАХ-3.4.5, НХТ-2.4.20** | | | | | | |
| 5.1 | **Арга хэмжээ-24:**<br>“Шинэ хэвийн байдал” нийслэлийн аялал жуулчлалыг сэргээх, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | Ковидын дараах нийслэлийн Аялал жуулчлалыг сэргээх хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5 зорилтын 27 арга хэмжээний биелэлт 2023 оны жилийн эцсийн байдлаар 80 хувийн хэрэгжилттэй байна. | 70% |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 2:** Нийслэлд үндэсний спорт болон бусад спортыг төрлийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэнэ. НЗДҮАХ-2.2.2 | | | | | | | |
| 6 | **Зорилт 6: Зүүн Азийн Залуучуудын анхдугаар наадмыг өндөр түвшинд зохион байгуулна. НЗДҮАХ-2.2.2.4, НХТ-1.2.9** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | **Арга хэмжээ-25:**<br>“Улаанбаатар 2023” Зүүн Азийн залуучуудын наадмын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, оролцогчид, жуулчдад хотыг танилцуулах “City vollenter” буюу хотын сайн дурын ажилтын бүртгэл, сургалт зохион байгуулахад хамтран ажиллана. | - | Хамтран зохион байгуулсан сургалтын тоо | -. | 2 | "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадамд хөтөч тайлбарлагчаар ажиллах сайн дурын ажилтны бүртгэлийг 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 14-ний өдрийн хугацаанд цахимаар зохион байгуулж сонгон шалгаруулалт тэнцсэн 50 сайн дурын ажилтанд зориулсан сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, “Гайд боловсролын төв”, “Улаанбаатар хотын музей” зэрэг байгууллагуудтай хамтран “Хөтөч, тайлбарлагчдын соёл, ёс зүй, олон улсын стандарт”, “Улаанбаатар хотын түүх соёл, хотын танилцуулга, түүхэн дурсгалт газар, гол үзмэрүүдэд тайлбар хийх нь”, “Гадаадын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хууль эрх зүйн мэдлэг олгох” сэдвүүдийн хүрээнд зохион байгууллаа. Мөн "Улаанбаатар спорт менежмент" ХК -аас зохион байгуулсан "COME TOGETHER" сайн дурынхны нэгдсэн сургалтад хөтөч тайлбарлагчаар ажилласан сайн дурын 50 ажилтан хамрагдсан. | 100% |
| 6.2 | **Арга хэмжээ-26:**<br>Монголын үндэсний уламжлалт бэсрэг наадмыг хамтран зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмын үеэр Үндэсний олимпын хорооны баг тамирчид, оролцогчдод зориулан зохион байгуулах бэсрэг наадмын хөтөлбөрт тусгах санал хүргүүлсэн. | 70% |
| 6.3 | **Арга хэмжээ-27:**<br>Хүлээн авах зочид буудлуудын судалгааг гаргах, үйлчилгээний стандартад хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадамд 7 Үндэсний олимпын хорооны 838 тамирчин, 226 дасгалжуулагч, Азийн спортын холбоодоос томилогдсон 123 техникийн болон тэмцээний шүүгч, дотоодын 191 шүүгч, техникийн ажилтан, 16 өндөр түвшний зочид, 22 Үндэсний олимпын хорооны удирдлага нийт 1416 хүн оролцсон.<br>Олон улсын тамирчид, дасгалжуулагчид болон шүүгчид, техникийн ажилчид, албаны төлөөлөгчдийг хүлээн авч байршуулах 27 зочид буудлын судалгаа, мэдээллийг гаргаж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлснээс 13 зочид буудалд хүлээн авч байршуулан спортын төрөл тус бүрээр болон хүндэт зочид, Үндэсний олимпын хороодын төв штаб хэлбэрээр зохион байгуулж байршуулах ажлыг хамтран зохион байгуулав. | |
| 6.4 | **Арга хэмжээ-28:** Наадмын үеэр зохион байгуулах аялал жуулчлалын зорилтод хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | - | 100 | Улаанбаатар хот болон хот орчмын аяллын маршрут, арга хэмжээний талаарх мэдээллийг “Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулах хороо, "Улаанбаатар спорт менежмент" ХК-д хүргүүлсэн. “Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадам багтсан спортын 11 төрлийн мэргэжлийн холбоод хотын аяллыг хариуцан зохион байгууллаа. | 100% |
| 7. | **Зорилт 7: Хуулиар олгосон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 7.1 | **Арга хэмжээ-29:** Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 90 | 100 | Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 90.0%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилтын 11 арга хэмжээний хэрэгжилт 92.0%, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 зорилтын 20 арга хэмжээний хэрэгжилт 94.0%-ийн биелэлттэй хэрэгжсэн. | 100% |
| 7.2 | **Арга хэмжээ-30:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Нийслэлийн Засаг даргын захирамж, Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн холбогдох хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 95 | 100 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 5 заалт, Нийслэлийн Засаг даргын захирамжийн 30 заалт, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын 8 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 91.6%, Нийслэлийн Засаг даргын захирамжийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелэлт 97.0%, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлт 96.25%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. | |
| 7.3 | **Арга хэмжээ-31:** Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ. | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 90 | 100 | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн 2023 оны жилийн эцсийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:<br>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 100%, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт 95%, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 100%, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 90.0%, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5 зорилтын 11 арга хэмжээний хэрэгжилт 92.0%, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний 1 зорилтын 20 арга хэмжээний хэрэгжилт 94.0%, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 91.6%-иар тус тус үнэлэгдсэн. | 100% |
| 7.4 | **Арга хэмжээ-32:** “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах | Байгууллагын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 95 | 100 | 1.Албан хаагчдын 2023 оны сургалтын төлөвлөгөөний дагуу “Ажлын байр ба баг хамт олны үр дүнтэй харилцаа”, “Хөрөнгө орлогын мэдүүлэг бөглөх арга зүй”, “Засгийн газрын худалдан авах ажиллагааны удирдлага, зохион байгуулалт”, “Урт хугацааны бодлого, төлөвлөлт”, “Төрийн байгууллагын баримт бичиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллана. | | | | | боловсруулах арга зүй, Архив албан хэрэг хөтлөлт", "Шинэ сэргэлтийн бодлого, Алсын хараа 2050", "Үр дүнд суурилсан хяналт шинжилгээ үнэлгээ", "Чанарын менежментийн тогтолцоо", "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, биелэлтийг тайлагнах талаар шинээр батлагдсан хууль тогтоомжийн зохицуулалт" зэрэг 28 удаагийн сургалтад давхардсан тоогоор 81 албан хаагчийг хамруулж, англи хэлний сургалтад 2 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 3 албан хаагч, Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны сургалтад 5 албан хаагчийг хамруулж суралцах хугацаанд цалинтай чөлөө олгосон.<br>2."Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд Хүний нөөцийн нэгдсэн системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлт мэдээллийг тогтмол оруулан холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хүрээнд шинээр 1 албан хаагчид зэрэг дэв олгуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 6 албан хаагчид шинэчлэн олгож, 1 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн.<br>"Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан албан хаагчдын 32 хүүхдэд хүндэтгэл үзүүлж мөн холбогдох журмын хүрээнд жирэмсний амралттай, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчид тус бүр 500.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| 7.5 | **Арга хэмжээ-33:**<br>Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 95 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бүтэц, орон тооны хязгаарыг 18 албан хаагчтай, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс гэсэн 2 зохион байгуулалтын нэгжтэйгээр баталсан бөгөөд Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хүрээнд удирдах албан тушаалын 1, гүйцэтгэх албан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалын 2 нийт 3 албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг хүргүүлэн тусгай сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн албан хаагчдаас сул орон тоог нөхөх ажлыг ажлыг зохион байгууллаа. | |
| .7.6 | **Арга хэмжээ-34:** Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 95 | 100 | Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, эмэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх үр нөлөө эмэгтэйчүүдийн манлайлал болон өсвөр үеийн жендэрийн талаарх ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, эрэгтэй эмэгтэйчүүдэд тулгарч буй жендэрийн асуудлын талаар мэдээлэл өгөх, өсвөр үеийн хүүхдүүдийг жендэрийн мэдлэг мэдээлэлтэй мэдрэмжтэй иргэн болгож төлөвшүүлэх үндэсний хэмжээний “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” нэг сарын аянд нэгдэн ажилласан.<br>Аяны хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 14-нөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд нийт албан хаагчдын дунд “Жендэр гэж юу бэ?” эссэ бичлэгийн уралдаан, “Жендэрийн тухай ойлголт” сургалт зохион байгуулав.<br>Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтын хүрээнд 0-6 настай хүүхэдтэй 5 албан хаагчид хүүхдээ хичээл, сургуульд нь хүргэж өгөх ажлын цагийн зохицуулалт хийж, мөн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд болон тэмдэглэлт өдрүүд, амралтын өдрүүдэд ажилласан нийт 42 (давхардсан тоогоор) албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгосон. | 100% |
| 7.7 | **Арга хэмжээ-35:** Авлигалаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хանган, хүнд суртлыг багасгаж, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэн ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 100 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 14 албан хаагч хугацаандаа хөрөнгө орлогын мэдүүлгээ тайлагнаж, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн удирдах албан тушаалд 1, гүйцэтгэх албан тушаалд 6 нийт 7 албан хаагчийг томилсон. Авлигатай тэмцэх газраас зохион | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан “Авлигын эсрэг нэгдье” аянд нэгдэж байгууллагын цахим хуудсанд холбогдох чиглэлээр 9 төрлийн мэдээ, мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй байршуулж 26,500 хүнд хүргэж ажилласан.<br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу “Тушаалын төслийн саналын хуудас”-ыг газрын дарга, хэлтсийн дарга нараар тухай бүрд нь бөглүүлж, ашиг сонирхлын зөрчилтэй, эсэх мэдэгдлийг гаргуулан ажиллаж байна. Тус хуулийн 8.2. дахь заалтын дагуу албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдсэн, энэ хуулийн 29.2.2. дахь заалтыг зөрчсөн албан хаагч байхгүй болно.<br>Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2023 оны А/45 дугаарын тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-ны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, 3 гишүүнийг чадавхжуулах зорилгоор “Төрийн албан хаагчийн харилцаа”, “Ёс зүйн дэд хорооны чиг үүрэг” сэдэвт сургалтад, 2023 онд төрийн албанд шинээр томилогдсон 16 (давхардсан) албан хаагчийг Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сэдэвт сургалтад, Авлигаас урьдчилан сэргийлэх, хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн тайлагнах арга зүйн сургалтад 17 албан хаагчийг хамруулсан. | |
| 7.8 | **Арга хэмжээ-36:**<br>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 100 | Байгууллагын 2023 оны төсөвт бичиг хэргийн зардалд 1,466,000 төгрөг, тээвэр шатахууны зардалд 7,708,800 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 4,800,000 төгрөг нийт 13,974,800 батлагдаж 2023 оны эхний 11 сарын байдлаар бичиг хэргийн зардалд 1,374,140 төгрөг, тээвэр шатахууны зардалд 5,593,550 төгрөг, шуудан холбоо, интернэтийн төлбөрт 3,708,883 төгрөг нийт 10,676,573 төгрөг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулсан. Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд эвент арга хэмжээ зохион байгуулахад 662,034.0 төгрөг, томилолт, хурал, зөвлөгөөн, уулзалт зохион байгуулахад 89,941.9 төгрөг, маркетинг, сурталчилгаа, хамтын ажиллагааны чиглэлээр 440,042.5 төгрөг нийт 1,192,019,435 (нэг тэрбум нэг зуун ерэн хоёр сая зуун арван есөн мянга дөрвөн зуун гучин тав) төгрөгийг батлуулж, санхүүгийн баримтын бүрдлийг тухай бүр хангуулан тайлагнан ажиллав. | |
| 7.9 | **Арга хэмжээ-37:**<br>Байгууллагын үндсэн, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг хангаж биелүүлнэ. | - | Орлого бүрдүүлэлт | 37,829.0 | 30,000.0 | Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг бүрэн хангаж, “Сити тур” төслийг 2023 оны 05 сараас 10 сарын хугацаанд хэрэгжүүлэн 30,081,000 (гучин сая наян нэгэн мянга) төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. | 100% |
| 7.10 | **Арга хэмжээ-38:**<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, төсвийн ил тод байдлыг хангана. | - | Хэрэгжилт, хувиар | 100 | 100 | Шилэн дансны тухай хууль холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж 2023 оны эхний 11 сарын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 46, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр 22, бусад чиглэлээр 61 буюу 129 ажил, арга хэмжээний мэдээ мэдээллийг www.info.shilendans.gov.mn цахим санд оруулж ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 7.11 | **Арга хэмжээ-39:**<br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг холбогдох хууль | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 100 | Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аялал жуулчлалын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний хүрээнд Бэлхийн амны “Хүннүгийн язгууртны булш” цогцолборын тохижилтын ажлын нийт санхүүжилт 672,141,955 (зургаан | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоомжид нийцүүлэн шуурхай хугацаанд нь чанартай зохион байгуулж гүйцэтгэнэ. | | | | | зуун далан хоёр сая нэг зуун дөчин нэгэн мянга есөн зуун ерэн тав) төгрөг үүнээс 2022 онд 348,700,000 (гурван зуун дөчин найман сая долоо зуу мянга) төгрөг, 2023 онд 170,000,000 (нэг зуун далан сая) төгрөгийн санхүүжилтийг захиалагч талаас ажлын гүйцэтгэлээр олгосон. Тохижилтын ажил 2023 оны 11 сарын байдлаар 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ байхгүй. | |
| 7.12 | **Арга хэмжээ-40:** Нийслэлд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагатай хамтран судалгааны ажил зохион байгуулна. | - | Судалгааны ажлын тоо | 2 | 2 | СЭЗИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвтэй хамтран “Монголын аялал жуулчлалын салбарын статистикийн мэдээлэл хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа-2023” судалгааны ажлыг зохион байгууллаа.<br>Аялал жуулчлалын статистик аргачлалыг боловсронгуй болгох тоон мэдээллийг цуглуулах маягтуудыг боловсруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Үндэсний Статистикийн хороо, нийслэлийн Аялал жуулчлалын газар болон аялал жуулчлалын салбарын багш, судлаачдын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж аялал жуулчлалын статистик үзүүлэлт тооцох аргачлал, статистик мэдээний маягт, түүнийг нөхөх заавар, улирлын мэдээний нэгтгэл хүснэгт зэрэг 9 баримт бичгийн төслийг боловсруулан 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан “GO TO MONGOLIA” үндэсний чуулганы үеэр Аялал жуулчлалын статистик тооцох аргачлал” сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж 40 орчим хүн оролцлоо. | 100% |
| 7.13 | **Арга хэмжээ-41:** Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100 | 100 | Нийслэлийн удирдах ажилтнуудын 31 удаагийн шуурхай зөвлөгөөнд оролцож, байгууллагын чиг үүрэгт хамаарах 81 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган, хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, холбогдох судалгааг тухай бүр цаг хугацаанд нь хүргэж ажилласан. | |
| 8. | **Зорилт 8: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 8.1 | **Арга хэмжээ-42:** “Сити тур” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Байгууллагын төсөв 60.0 | Хүний тоо | 4885 | 5,000 | “Сити тур” төслийг 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлж нийт 45 удаагийн аялалд 5052 гадаад, дотоодын иргэн, жуулчдыг хамруулж Улаанбаатар хотын аяллыг зохион байгууллаа. | 100% |
| 8.2 | **Арга хэмжээ-43:** Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвөөр дамжуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгнө. | - | Мэдээлэл, зөвлөгөө өгсөн иргэд, жуулчдын тоо | 10,000 | 15,000 | Жуулчны мэдээлэл, сурталчилгааны 7 төвөөр 2023 онд 10,741 гадаад, дотоодын иргэн. жуулчин үйлчилгээ авч, “Бүргэдийн баяр”, “Дээлтэй Монгол наадам”, “Даншиг наадам-Хүрээ цам” арга хэмжээ болон "Улаанбаатар травел экспо" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, “ITM Mongolia-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэг арга хэмжээний үеэр жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн цэгийг ажиллуулж 30,000 хүн нийт 40,741 гадаад, дотоодын иргэн., жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| 8.3 | **Арга хэмжээ-44:** Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон бусад худалдааны сувгаар дамжуулан аялал жуулчлалын салбар дахь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ. | - | Бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо | - | 10 | “VISIT ULAANBAATAR” брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, зах зээлд нийлүүлэх зорилгоор “Голден гоби”, “Зүймэл даавуун урлал”, “Хөсөг брэнд”, “Сувинер хаус”, “Тэрэм брэнд”, “Монгол бэлэг” зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагын 20 нэр төрлийн бүтээгдэхүүнийг туршилтаар гаргаж жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд, хамтран ажилладаг байгууллагуудын худалдааны цэгүүдэд буюу нийт 10 байршилд худалдаанд гаргасан.<br>“Бүргэдийн баяр-2023”, “Улаанбаатар травэл экспо”, “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль, “Дээлтэй Монгол наадам”, “Хүрээ цам-даншиг наадам”, “UB food фестиваль”, “Хийморь” морьт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зэрэг 7 арга хэмжээний үеэр давхардсан тоогоор 488 гаруй жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний худалдааг гарган 610,211,000 (зургаан зуун арван сая хоёр зуун арван нэгэн мянга) төгрөгийн борлуулалт хийж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан. | |
| 8.4 | **Арга хэмжээ-45:** Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй үйлчилгээний стандартуудыг шинэчлэн батлуулах ажлыг хамтран зохион байгуулна. | - | Боловсруул-сан стандартын төслийн тоо | - | 4 | Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны хуралдаанаас “Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж байгаа стандартуудыг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулан байгуулсан.<br>Тус ажлын хэсгээс салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа 10 стандартыг дахин хянах ажлыг зохион байгуулж эдгээрээс “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл үндсэн шаардлага MNS 5927:2008“, “Зочид буудлын ерөнхий шаардлага стандарт MNS4588:2008” стандартуудыг Монголын зочид буудлуудын холбоотой хамтран, “Аялал жуулчлал дэн буудлын ерөнхий шаардлага стандарт MNS5738:2007” стандартыг дэн буудал эрхлэгчдийн “Өргөө” холбоотой тус тус хамтран шинэчлэн боловсрууллаа. Боловсруулсан стандартуудаар 2023 оны 11 дүгээр сарын 09, 16-ны өдрүүдэд “УБ гранд”, “ИБИС” зочид буудлуудад хэлэлцүүлэг зохион байгуулж 19 зочид буудлын захирал, менежерүүд оролцлоо. Стандартын төслүүдийг Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд уламжлаад байна. | 90% |
| 8.5 | **Арга хэмжээ-46:** Зочлох үйлчилгээний стандартуудыг сурталчлах арга хэмжээ зохион байгуулна. | - | Арга хэмжээний тоо | 4 | 5 | Аялал жуулчлалын үйлчилгээний стандартуудыг танилцуулах, сурталчлах зорилгоор 2023 онд 5 арга хэмжээ зохион байгуулав.<br>1.Үндэсний болон хотын стандартуудыг танилцуулах зорилгоор Хотын стандарт, хяналтын газар, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газруудтай хамтран “Үйлчилгээ эрхлэх бүртгэл-Онлайн бизнес төв”, “Хотын стандартууд” сэдвүүдийн хүрээнд сургалт зохион байгуулж 5 дүүргийн нутаг дэвсгэрт үйл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа явуулдаг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын 355 удирдах ажилтан хамрагдлаа.<br>2.Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор стандартын үзлэг, хяналт шалгалтын ажлыг 2023 оны 05-10 дугаар сарын хооронд зохион байгуулж нийт 243 дэн буудал, зочид буудал, амралтын газар, жуулчны баазад үндэсний 3, хотын 3 нийт 6 стандартыг танилцуулж сурталчилсан.<br>3. Стандарт, хэмжил зүйн салбарын 100 жилийн ойг тохиолдуулан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Иргэдэд ээлтэй стандарт” өдөрлөгт оролцож 5 төрлийн үйлчилгээний стандартуудыг сурталчилсан.<br>4.“Зочин хүлээн авагч”, “Зөөгч”, “Өрөөний үйлчлэгч” сэдэвт 3 гарын авлагыг эмхэтгэн хэвлүүлж 120 аж ахуйн нэгжид тараасан.<br>5. “Хөтөч тайлбарлагчийн анхан шатны мэдлэг олгох”, “Жуулчин тээвэр, такси үйлчилгээний ажилтнуудын харилцаа хандлага”, “Жуулчидтай харилцдаг төрийн албан хаагчдын харилцаа хандлага” сэдэвт 3 төрлийн цахим сургалтын гарын авлага хичээлийг цахимаар үйлчилгээний байгууллагуудын ажилчдад хүргэсэн. | |
| 8.6 | **Арга хэмжээ-47:**<br>Зочид буудал, жуулчны баазуудыг од зэрэглэлд хамруулах ажлыг хамтран зохион байгуулна. | - | Байгууллагын тоо | 3 | 5 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 12 дугаар сарын ... өдрийн ... дугаар тушаалаар батлагдсан “Зочид буудал, жуулчны баазуудад зэрэглэл тогтоох ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна. Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 9 аж ахуйн нэгж, байгууллага зэрэглэл тогтоолгох хүсэлтээ ирүүлээд байна. Зэрэглэл тогтоох ажлыг 2023 оны 12 дугаар сарын 18-25-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.7 | **Арга хэмжээ-48:** Үндэсний их баяр наадам үзэх жуулчдын тасалбарын захиалга, хуваарилалтыг зохион байгуулна. | - | Тасалбарын тоо | 2,240 | 2,500 | Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадам үзэх гадаад жуулчдын тасалбар захиалгын хүсэлтийг 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрөөс 30-ны өдрүүдэд бичгээр болон байгууллагын цахим хуудсаар хүлээн авах ажлыг зохион байгуулж, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбооны төлөөллийг оролцуулсан наадмын жуулчин тасалбар хуваарилах Ажлын хэсгээс 189 аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгжүүдэд 2872 ширхэг тасалбар хуваарилан олгох ажлыг зохион байгуулав. | 100% |
| 8.8 | **Арга хэмжээ-49:** Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлж, аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгана. | - | Байгууллагын тоо | 20 | 20 | Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлыг уртасгах зорилгоор “Шинэ жилээр Монголд” хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлтийн аяныг 2022 оны 12 сарын 25-ны өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулж, байр сууцны үйлчилгээ, соёл, урлагийн байгууллага, ресторан, зоогийн газар, худалдааны төв зэрэг нийт 200 байгууллага 10-50 хүртэлх хувийн хямдралтай үйлчилгээг иргэд, жуулчдад санал болгож хөнгөлөлт, урамшуулалд хамруулсан. Одоогоор Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 13 амралтын газар 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 20-50 хүртэлх хувийн хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлж байна. | 100% |
| 8.9 | **Арга хэмжээ-50:** Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлж хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэлт-ийн хувиар | 99 | 100 | Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 131, хариугүй 539 нийт 670 албан бичгийг бүртгэж, 540 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан явуулсан.Ирүүлсэн 670 албан бичгээс 659 албан бичгийг эцэслэн шийдвэрлэж, 11 албан бичиг судалж байгаа төлөвтэй албан бичгийг 99.33%-тай шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.10 | **Арга хэмжээ-51:**<br>Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэнэ. | - | Шийдвэрлэлт-ийн хугацаагаар | 5 хоног | 5 хоног | Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 32 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.<br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 00 цаг 49 минут байна. | 100% |
| 8.11 | **Арга хэмжээ-52:**<br>“Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2022 оны архивын материалыг хүлээн авах, архивын нэгдсэн данс бүртгэл хөтөлнө. | - | Хадгаламж-ийн нэгжийн тоо | 130 | 130 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2022 оны байнга хадгалах 60, түр хадгалах 67, 70 жил хадгалах 3, тусгай төрлийн 27 нийт 157 баримтыг архивд хүлээн авч архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтөлсөн. | 100% |
| 8.12 | **Арга хэмжээ-53:**<br>Газрын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна. | - | Судалгааны тоо | - | 2 | 1.Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийн шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлж, иргэдээс гарсан санал, шүүмжлэлийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тусгаж, төрийн үйлчилгээг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг арилгах арга замыг тодорхойлох, төрийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тус газраас төрийн үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс цахим хэлбэрээр санал асуулгыг авч ажилласан.<br>2. Жуулчдад зориулсан арга хэмжээний чанар, үйлчилгээг сайжруулах, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, эдийн засгийн үр өгөөжийг тооцох зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдээр үйлчлүүлсэн болон “Улаанбаатар өвлийн наадам”, “Дээлтэй Монгол наадам”, “Хүрээ цам-даншиг наадам”, “Талын салхи олон улсын мото наадам”, “UB food фестиваль” зэрэг арга хэмжээний үеэр сэтгэл ханамжийн судалгааг 5400 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид, оролцогчдоос авч дүн шинжилгээ хийн үйл ажиллагаагаа сайжруулан ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.13 | **Арга хэмжээ-54:**<br>Байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, тайлан холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг нээлтэй байршуулж ажиллана. | - | Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо | 1778 | 2000 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээлэл байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тогтмол шинэчлэн ажилласан.<br>Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn, www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд 2023 онд давхардсан тоогоор 2382 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 1,699,106 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан..<br>Тухайлбал:<br>• www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 749 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 245,000<br>• www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 179 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 54,755<br>• https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 1248 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 29,248 хандалтын тоо 1,247,550<br>• https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 117 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 311, хандалтын тоо 92,577<br>https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 89 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 342, хандалтын тоо 59,224 байна. | 100% |
| 8.14 | **Арга хэмжээ-55:**<br>Улаанбаатар хотын аялал жуулчлалын салбарын дата мэдээллийн санг шинэчлэн хөтөлнө. | | Багц мэдээллийн тоо | 17 | 20 | Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, олон улсын чанартай зохион байгуулагддаг аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, арга хэмжээ болон хот орчмын болон аймаг орон нутгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | очиж үзэж болох дурсгалт газрууд, үзвэр үйлчилгээний газрууд, аяллын маршрут, тусгай сонирхлын аялал зохион байгуулдаг сайн дурын клубүүдийн судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан үүсгэсэн.<br>Жуулчны мэдээллийн санд тур оператор байгууллага, музей, үзвэр үйлчилгээний байгууллагын цагийн хуваарь үйлчилгээний мэдээлэл, зочид буудал, амралтын газар, жуулчны баазуудын үйл ажиллагааны мэдээлэл, ресторан зоогийн газруудын мэдээлэл, эвент, олон улсын арга хэмжээний хуваарь, мэдээлэл, сүм хийд, шашны байгууллагуудын мэдээлэл зэрэг 25 ангиллаар 10.000 гаруй аж ахуй нэгж байгууллага, үзвэр үйлчилгээг багтаасан мэдээллийн санг тогтмол шинэчлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангаж ажилласан. | |
| Нийт дундаж 94.3 хувь-Бүрэн хэрэгжсэн. | | | | | | | |

ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ГАНБОЛД

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН О.НЯМБАТ